



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 онь 02 сарын 27 өдөр

Дугаар А/118

Хэрлэн сум

Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын
газарт дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Залуучуудын хөгжлийн дэмжих тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.6 дахь заалт, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.15 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ийн 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий аймгийн Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газраас ирүүлсэн хүсэлтийн дагуу Монгол Улсын Засгийн газраас 2025 оныг залуучуудын жил болгон зарласантай холбогдуулан залуучуудад зориулсан “Share office” байгуулахад 13,000,000 (арван гурван сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дэмжлэг үзүүлэхэд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн байгууллага, иргэдээс тавьсан санал хүсэлтийг шийдвэрлэх зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (А.Жаргалсайхан)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Өнөрцолмон)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.АЮУРБУНЬ



